

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, төрийн байгууллагуудад цаг үеийн асуудлаар нийт 9 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан.

Засаг даргын зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж 6 асуудлыг шийдвэрлэсэн. Үүний хүрээнд: Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 иргэний эмчилгээний зардалд 800.0 төгрөгний буцалтгүй тусламж, 2 иргэнд 800.0 мянган төгрөгний дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн.

Тайлант сард Аймгийн Засаг даргад 7 өргөдөл, аймгийн ЗДТГ-ын даргад 5 өргөдөл тус тус ирсэн. Аймгийн Засаг даргад ирсэн 5 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 2 өргөдөл шийдвэрлэх шатанд байна, Засаг даргын Тамгын газрын даргад ирсэн 5 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг хуваарийн дагуу үр дүнтэй зохион байгуулан орон нутгийн Залуус телевиз, Монголын мэдээ сонин, Давхар дэлгэц ХХК, Монголын үндэсний радио зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тайлант сард аймгийн цахим хуудсанд 41 мэдээлэл байршуулж 10445 иргэн хандсан нь өмнөх сарын хандалтаас 19 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулахад чиглэсэн дэд хөтөлбөрийн хүрээнд сум багийн Засаг дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдыг арга зүй мэдээллэр хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 84 албан хаагч оролцсон. Тус сургалтын үеэр жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг сагсан бөмбөг, гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд халдварт улаан бурхан өвчний 1 тохиолдол илэрсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссыг хуралдуулж, Сүмбэр сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/07 дугаар Захирамжаар 03 дугаар сарын 11-ний өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хязгаарлалтын дэглэм тогтоож аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан зарим арга хэмжээнүүдийг цуцалсан. Мөн ХӨСҮТ-ийн баг орон нутагт ажиллаж, судалгаа хийсэн. Улаан бурхан өвчин, түүнээс үүдэлтэй менингоэнцефалит, “Гар хөл амны өвчин”, “Салхин цэцэг өвчнөөс сэргийлэх зөвлөмж”, “Хоолой зайлах уусмал бэлтгэх арга” зэрэг амьсгалын замын халдварт өвчнүүдээс сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг түгээж, сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулан 1012 сурагч, 726 цэцэрлэгийн хүүхдийг хамруулан шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулж ажилласны үр дүнд халдварт өвчний тархалт зогссон.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2019 оны 03 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 1439473.9 мян төгрөг төвлөрүүлэхээс, 1439476.9 мян төгрөг төвлөрүүлж 100 хувь, Улсын төвлөрсөн төсөвт 599530.0 мян төгрөг төвлөрүүлэхээс, 599530.0 мян төгрөг төвлөрүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн дагуу зохион байгуулагдсан 2019 оны 03 дугаар сарын сугалааны тохирлоор аймгийн хэмжээнд 137 иргэн 30000-100000 төгрөгийн хонжворын азтан болсон.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 3200.6 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 1905.9 сая.төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн

орлогын шилжүүлэг 105.6 сая төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн хэлтэс: 2019 оны 02 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж аймгийн болон хэлтсийн цахим хуудсанд байршуулж хэвлэмэл хуудсаар 55, цахимаар 140 хэрэглэгчид хүргүүлсэн.

Хүн ам, орон сууцны тооллогын аймгийн комиссын хуралдааныг зохион байгууллаа. Тус хуралдаанд сум багийн нийт 39 хүн хамрагдаж Статистикийн тухай хууль, Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн талаар мэдээлэл олгосон.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Нийгмийн даатгалын сангийн 2017, 2018 онуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 5740.1 мян төгрөгийн зөрчил илрүүлж, дутуу олгосон 3707.8 мян төгрөгийг холбогдох хүмүүст буцаан олгуулахаар, илүү олгосон 138.4 мян төгрөгийг орон нутгийн орлого болгохоор улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон.

Мөн Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үйлчилгээний 2017, 2018 оны үйл ажиллагааны баримтыг шалгаж 2 өрхийн үйлчилгээг түтгэлзүүлж, 44 өрхийн амьжиргааны түвшинг дахин үнэлж халамжийн үйлчилгээг цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх, 4 өрхийг хүнс тэжээлийн дэмжлэг авах үйлчилгээнээс хасч түтгэлзүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгосон:Тэтгэвэр

№	Төрөл	2018.03.24		2019.03.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/	
1	Өндөр настан	1530	1671995,8	1666	1954737,3	36
2	Тахир дутуу	277	240987,1	307	250748,5	30
3	Тэжээгчээ алдсан	130	104499,4	124	104539,2	-6
4	Үйлдвэрийн осол	47	66816,7	50	24842,9	3
	Нийт дүн	1984	2084299,0	2147	2334867,9	163

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2018.03.24		2019.03.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	338	37121,3	341	32722,7
2	ЖБА тэтгэмж	120	154201,3	67	89862,1
3	Оршуулга	11	11000,0	16	16000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	11	13810,3	3	1128,4
5	Ажилгүйдэл	32	49050,7	38	88152,9
	Нийт дүн	512	265183,6	465	227866,1

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2018.03.24	2019.03.24
Шинээр	56	55
Мөнгө тушаасан	453	455
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	41656,9	54118,0

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 8, зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаагийн мэдэгдэл 48 аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн Прокурорын газартай хамтран эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, цаашид анхаарах асуудал, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтийн талаар зөвлөгөөнийг зохион байгуулж 20 эрх бүхий албан тушаалтныг хамрууллаа.

Нефть хангамжийн салбарын 40 ажилтанд "Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрэм", "Зөрчлийн тухай хууль", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-иар сургалт зохион байгууллаа.

"Нэг хором" аяны хүрээнд "Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "Хүүхэд хүмүүжлийн эерэг аргад суралцья", "Хүүхдээ хамгаалья", "Хүүхэд хамгааллын 108 дугаар"-ын талаар 4 төрлийн сэрэмжлүүлэг, санамжийг аж ахуйн нэгж байгууллагууд, Ерөнхий боловсролын сургуулиудын мэдээллийн самбарт байршуулсан. Мөн аяны хүрээнд "Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг" гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж 18 байгууллагын давхардсан тоогоор 3552 албан хаагч хамрагдсан.

2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгон зарласантай холбоотойгоор иргэддээ илүү ойр, нээлттэй ил тод байж тэдний санал хүсэлтийг шуурхай авч, шийдвэрлэж ажиллах, мөн ЦЕГ-аас 2019 онд дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг зөв, оновчтой зохион байгуулах зорилгоор Шивээговь сумын Сэвхүүл баг, Баянтал сумын Лүн багийн иргэд, Төмөр замын ажилчид, Сүмбэр сумын ахмадуудад 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлыг танилцуулан, санал асуулга авч ажилласан.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмээр 5, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 3, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, нийт 13 удаа, 13 аж ахуйн нэгж байгууллагын 5238 иргэнд сургалт зохион байгуулж, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлагыг 1305 иргэнд тараан, аймгийн Залуус телевизээр өдрийн 6 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлсэн.

Архивын ажлын чиглэлээр:

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1 хөмрөгийн 1990-2003 оны 15 хадгаламжийн нэгжийн 2049 хуудас баримтын 1570 заалт бүхий 14895 хүний нэр, 1569 байгууллагын нэр, 4848 газар зүйн нэр, нийт 1943 хуудас баримтыг программд холбож цахимжуулалтын мэдээг сар бүрийн 25-ны дотор Архивын ерөнхий газарт хүргүүлж байна. Архивын баримтаас 8 иргэнд лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлсэн.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан -46
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -45
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 30
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 8
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо -0

- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо -0
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 0
- Нас барсныг бүртгүүлсэн тоо -8
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -21
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -23

Бүгд-182

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 4
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 48
- Гэрээний бүртгэл - 20
- Барьцааны гэрээний бүртгэл - 258
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -2

Бүгд-332

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -1
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл - 0

Бүгд-02

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар -1
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 7
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл-1

Бүгд-9

Нийт үзүүлсэн үйлчилгээ – 734

ЦАГДААГИЙН ХЭЛТЭС

Нэг. Гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдал

Тайлант сард иргэд, хуулийн этгээдээс 135 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 53 буюу 39.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 82 буюу 60.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

32 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс гэмт хэрэг 1-ээр буюу 3 хувиар буурсан.

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Хүнд гэмт хэрэг 5 бүртгэгдсэн нь 4 –өөр буюу 44 хувиар буурч
- Хөнгөн гэмт хэрэг 27 бүртгэгдсэн нь 3-аар буюу 12.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд тайлант сард гэмт хэргийн илрүүлэлт 26.7 хувьтай байгаа нь өмнөх мөн үеийнхээс 7.9 хувиар буурсан байна.

Нийт 3311 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1633 буюу 97.3 хувь өссөн үзүүлэлттэй байна. Нийт 3250 иргэнийг 100680.0 сая төгрөгөөр торгож, зөрчлийн хэрэг нээж, хялбаршуулсан журмаар 17 иргэнийг 14550.0 сая төгрөгөөр торгож, ердийн журмаар 3233 хүнийг 86130.0 сая төгрөгөөр торгож, 18 иргэнийг баривчилж, 30 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Согтуугаар үйлдсэн 59, эмэгтэй хүн оролцсон 8, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил 9 тус тус бүртгэгдсэн.

Зөрчилд холбогдогчдоос төрийн албан хаагч 2, хувийн хэвшлийн байгууллагын ажилтан 5, хувиараа хөдөлмөр эрхлэгч 15, ажилчин, малчин 9, ажилгүй 8, бусад 26 хүн бүртгэгдсэн.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, зөрчилд холбогдсон нийт 136 хүнийг эрүүлжүүлсэн нь урд оны мөн үеэс 51-ээр буюу 60 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс эмэгтэй 10, төрийн алба хаагч 1, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 6, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1, төрийн бус байгууллагын ажилтан 1, малчин 4, оюутан 1, ажилгүй 121, бусад 1 хүн байна.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

Шүүхийн шинжилгээний албанаас хэргийн газрын үзлэгт нийт 14 удаа оролцсон. Үүнээс хүний амь нас хохирсон хэргийн 4, хулгайн гэмт хэргийн 2, зам тээврийн ослын 7, бусад хэргийн газрын үзлэгт 3 удаа оролцож, хэргийн газраас гутлын мөр 4, тээврийн хэрэгслийн мөр 6, бусад ул мөрийг бэхжүүлж, эд мөрийн баримтыг хураан авч хэргийн материалд хавсаргасан. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 428 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Тайлант хугацаанд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 26-г хийж дүгнэлт гаргасан.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР-425 ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИ

Шүүхээс шинээр 20 гүйцэтгэх хуудасны 250615.4 төгрөгийн гүйцэтгэх баримт бичиг хүлээн авч цахим бүртгэлд бүртгэлээ.

2019 оны 03 дугаар сард хүүхдийн тэтгэлгийн 2 гүйцэтгэх баримт бичиг, төлбөрийн 9 гүйцэтгэх баримт бичгийн 34500.6 төгрөгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 17.6 хувьтай байна.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Тайлант сард төлөвлөгөөт шалгалтыг 31 газарт, зөвлөн туслах үйлчилгээ 3 газарт гүйцэтгэж, шалгалтын явцад илэрсэн зөрчлийг үндэслэн 7 газарт албан шаардлага, улсын байцаагчийн 1 акт, 3 зөвлөмж, “Их” эрсдэлтэй үнэлэгдсэн 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээр дүгнэлт гаргаж тусгай зөвшөөрлийн комисст хүргүүлсэн. Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн дагуу 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 130.000 төгрөгийн торгууль тавьж 100 хувь барагдуулсан.

Үүнд: Хүнсний давсны худалдаалалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Хяналтын явцад давсны 8 дээжийг шинжилгээнд хамруулсан бөгөөд 3 шинжилгээний дээжийн хариу гараагүй байгаа, хариу гарсан 5 давсны шинжилгээний дүнгээр 1 давс нь иоджуулаагүй, 2 давс нь иодын агууламж “Хүнсний зориулалттай иоджуулсан байгалийн давсны “Техникийн ерөнхий шаардлага MNS 5046: 2001” стандартад заасан хэмжээнээс 2-4-өөр бага, 1 давс нь иодын агууламж стандартад заасан хэмжээнээс 2-оор их, 1 нь стандартын шаардлагад нийцсэн. Шинжилгээний дүнд үндэслэн 2 газарт дүгнэлт гарган хүргүүлсэн.

Нялх балчир хүүхдийн хүнс, түүний сав баглаа боодол, шошгонд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. 6 газарт хяналт хийхэд, 2 газарт хүүхдийн хүнс худалдаалж байсан бөгөөд шалгалтын явцад ямар нэг зөрчил илрээгүй.

Тайлант сард нийт 3 удаагийн сургалт зохион байгуулж 175 иргэнийг хамруулж, 360 ширхэг гарын авлага, материалыг хэвлэн тараасан байна.

Үүнд: 2019 оныг Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгон зарласантай холбогдуулан төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хариуцлагыг сайжруулах, хамтын хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, усаар хангагч байгууллага, цэвэршүүлсэн усны үйл ажиллагаа явуулж

байгаа иргэн, аж ахуй нэгж, цехийн ажилтнуудад “Лабораторийн шинжилгээнд дээж өгөхдөө анхаарах зүйлс” сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 20 иргэн хамрагдсан.

“Байгаль орчны засаглал, Хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн даатгалын багц хуулиудаар 5 аж ахуйн нэгж байгууллагын 35 ажилтанд сургалт зохион байгуулсан. Сургалтанд хамрагдсан иргэдэд хяналтын чиглэлээр бэлтгэсэн 3 төрлийн 75 ширхэг, нийгмийн даатгалын байгууллагын 5 төрлийн 125 ширхэг нийт 200 ширхэг гарын авлагыг тараав.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Гал түймэр унтраах, аврах 37 дугаар анги, Эрэн хайх, аврах бүлгийн бие бүрэлдэхүүн Сүмбэр сумын гэр хороолол, айл өрхүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг хийсэн. Үзлэгээр 280 айл өрхөөр явж, 38 зөрчил илрүүлж, 28 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 508 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийсэн.

Тайлант сард “Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, 2017 оны 67 дугаар тогтоолыг танилцуулах, гамшиг, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 удаагийн сургалт зохион байгуулж 293 албан хаагч болон иргэдийг хамруулсан.

2019 онд тус аймагт зохион байгуулагдах гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлыг хангуулах зорилготой аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгт аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах 12 алба, ерөнхий зориулалттай 3 анги, тусгай зориулалттай 18 мэргэжлийн анги, 32 бүлэг, сайн дурын 3 хэсэг, 44 хуулийн этгээд, байгууллагын 1024 албан хаагч, ажилтан хамрагдаж, цаашид хэрэгжүүлэх ажил, бэлтгэл бэлэн байдлаа хангах талаар үүрэг чиглэлийг өгч ажилласан.

Мөн Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоол, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 1/447 дугаар үүргийг хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургаж дадлагажуулах зорилгоор “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль”-ийг 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 16:00 цагт зохион байгууллаа. Уг дадлага, сургуульд аймгийн 3 сумын 69 төрийн болон, төрийн бус байгууллагын нийт 2304 ажилтан, албан хаагч, 687 иргэн, сургууль, цэцэрлэгийн 3997 хүүхэд хамрагдлаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ,СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр:

Дэлхийн Зөн Олон улсын байгууллага, Боловсрол, соёл урлагийн газар, Сүмбэр сумын 2 дугаар сургууль, 6 дугаар цэцэрлэгтэй хамтран хэрэгжүүлж буй “Гэрээр айлчлах аргачлал” төслийн сургалтанд нийт 25 багш, ажилчид хамрагдаж, төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

“Эх соёл-Их үндэс” хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуульд 5 кабинет, цэцэрлэгүүдэд “Зан үйлийн өргөө” байгуулах, соёлын байгууллагуудад “Техник хэрэгсэл” нийлүүлэх ажлын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын санал, техникийн тодорхойлолтыг боловсруулж УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэгт хүргүүлээд байна.

Соёлын чиглэлээр:

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо, Дуу бүжгийн Боржигин чуулга хамтран эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан

2019 оны 03 дугаар сарын 07-ны өдөр баярын хурал, “Гоо үдэш” цэнгүүнийг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 250 гаруй хүн оролцсон.

Аймгийн “Боржигин өв музей”, Сүмбэр сумын ЗДТГазар, Дэлхийн зөн Олон Улсын байгууллага хамтран хөгжих өрхүүдийн дунд “Боржигин өв соёл” өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгөөр Боржигин дэг, өв соёл, ёс заншлыг харуулсан танин мэдэхүйн тэмцээнүүдийг зохион байгуулсан бөгөөд өдөрлөгт нийт 107 иргэн оролцсон.

Аймгийн Нийтийн номын сан “Ном эрдэм” 2 сарын аяны хүрээнд “Номыг бүтээлчээр уншуулах арга зүй эзэмшүүлэх” сургалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын 110 багшийг хамруулсан.

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, оролцоо, эрх хамгааллын чиглэлээр:

Аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлөөс санаачлан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран аймаг, сумдын залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, гишүүдийг идэвхижүүлэн, тэднээр дамжуулан орон нутгийн залуучуудын харилцаа, хандлагад эерэгээр нөлөөлөх, идэвхи, оролцоог нэмэгдүүлэх, 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох зорилгоор аймгийн Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн нэгдсэн уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд нийт 50 гишүүн хамрагдсан.

Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн төвийн үндсэн сургалт болох өсвөр үе, залуучуудад амьдрах ухааны чадвар олгох модуль хичээлийн хүрээнд 5 дугаар сургуулийн нийт 50 сурагчид “Зорилготой байх, Зорилгоо тодорхойлохуй” сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулсан.

2019 оны 03 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд Хүүхдийн болон зорилтот бүлгийн өрхүүдийн сайн сайхны төлөө, тэдний бүх талын хэрэгцээнд зориулан сургагч багш бэлтгэх зорилгоор Дэлхийн зөн ОУБ-тай хамтран “Гэр бүлийн баяр хөөр” сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 28 иргэн хамрагдлаа. Сургалтын үр дүнд хүүхэдтэйгээ харилцах эерэг харилцааны болон хүмүүжлийн эерэг аргыг эзэмшсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

ᠮᠤᠴᠢᠯᠡᠭᠡᠨ	2018 оны 03 дугаар сарын 20-ны байдлаар	2019 оны 03 дугаар сарын 20-ны байдлаар
ᠣᠣᠳᠠᠨᠢ ᠶᠣ	131	89
ᠠᠶᠣᠳᠡᠭᠡᠢ ᠳᠣᠳᠣᠭᠡᠨ	0	1
ᠠᠶᠢᠳᠤ ᠳᠣᠳᠠᠨᠢ ᠳᠤᠯᠤᠰᠤ	131	89
ᠠᠶᠢᠳᠤᠭᠡᠢ ᠳᠣᠳᠣᠭᠡᠨ	0	0
ᠯᠠᠨ ᠠᠠᠳᠠᠭᠡᠨ	11	11
ᠶᠢᠶᠡᠭᠡᠭᠡᠢ ᠯᠠᠨ ᠠᠠᠳᠠᠭᠡᠨ	3	2
ᠣᠶᠢᠨᠠ ᠠᠶᠢᠨᠠᠭᠡᠢ ᠯᠠᠨ ᠠᠠᠳᠠᠭᠡᠨ	0	0
0-1 ᠳᠤᠳᠣᠭᠡᠨ ᠯᠠᠨᠢᠳᠤ ᠳᠤᠯᠤᠰᠤᠭᠡᠢ ᠶᠢᠶᠡᠭᠡᠭᠡᠢ	0	2
1-5 ᠳᠤᠳᠣᠭᠡᠨ ᠯᠠᠨᠢᠳᠤ ᠳᠤᠯᠤᠰᠤᠭᠡᠢ ᠶᠢᠶᠡᠭᠡᠭᠡᠢ	0	0
ᠶᠢᠶᠡᠭᠡᠭᠡᠢ ᠠᠠᠳᠠᠨᠢ ᠳᠤᠯᠤᠰᠤᠭᠡᠢ	1289	997
ᠠᠶᠢᠳᠣᠭᠡᠨᠢᠳᠣᠭᠡᠢ ᠴᠢᠴᠡᠭᠡᠨ	25618	22963
ᠣᠠᠭᠡᠠᠠᠳᠣ ᠶᠡᠭᠡᠢ	72	49

Аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг “Инээмсэглэл-Эерэг хандлага-Иргэн төвтэй тусламж үйлчилгээ” уриан дор зохион байгууллаа. Уг зөвлөгөөнөөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн байгууллагууд 2018 онд хүн амын эрүүл мэндийг хамгаалах дэмжих чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил, ололт амжилт, алдаа

дутагдал, энэ онд хэрэгжүүлэх бодлого, төлөвлөлт чиглэлийн талаар харилцан санал солилцов.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

Волейболын Чойр хөгжлийн “DREAM ЛИГ-2019” тэмцээнийг зохион байгуулж эрэгтэй 5, эмэгтэй 8 багийн 140 гаруй тамирчид оролцон аваргуудаа тодруулсан.

Дархан-Уул аймагт Монголын хөл бөмбөгийн холбооноос зохион байгуулсан 21 аймгийн аварга шалгаруулах футзалын “Үндэсний цом 2019” тэмцээнээс багаараа мөнгөн медаль хүртлээ.

2019 оны Өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээнээс баг тамирчид 6 насны ангилалд нэг хүрэл, 8 хүртэлх насны ангилалд алтан медалийг тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд ажилгүй болон ажил идэвхтэй хайгч 18 иргэнийг бүртгэж, идэвхтэй ажил хайж байгаа бүртгэлтэй 55 иргэний мэдээллийг шинэчлэн бүртгэсэн. 14 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг хүргэж, ажил олгогч аж ахуй нэгж, байгууллагаас 33 сул ажлын байрны захиалга авч, 23 ажилгүй иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.

Солонгос хэлний түвшин тогтоох 15 дахь удаагийн шалгалтын бүртгэлийг зохион байгуулж, орон нутгийн харъяат 26 иргэн бүртгүүлээд байна.

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Малчдын чуулганд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөр болон жижиг зээл, төрөөс хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар мэдээлэл хүргэж, “Малчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, цаг агаар шинжих уламжлалт аргууд” сэдэвт гарын авлага тарааж, мэдээ мэдээллийг хүргэн ажилласан. Тус чуулганд нийт 165 малчин оролцож санал бодлоо солилцсон.

Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 35 иргэнд ажлын байрыг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн талаар сургалт, мэдээлэл хийсэн.

Иргэний бүртгэлийн хэлтсээс иргэдийн шилжилт хөдөлгөөний тайланг авч, мэдээллийн баазтай тулган өөрчлөлтийг хийж, 2019 оны 03 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нийт 3843 иргэнд 506778.1 мянган төгрөгийг олгоод байна.

№	Үзүүлэлт	2019.01.01 - 2019.03.20	
		Хүн тоо	Мөнгөн дүн
1	Халамжийн тэтгэвэр	217	107,743,590
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	279	50,000,670
3	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	169	29,973,620
4	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, насны хишиг	222	8,665,000
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	92	4,496,720
6	Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	208	10,896,780
7	Цалинтай ээж	822	77,431,780
8	Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	6	2,850,000
9	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1210	162,020,000
10	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		
11	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа		
12	Насны хишиг олголт	618	52,700,000
Нийгмийн халамжийн сангийн дүн		3843	506,778,160

Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журмын 2.1, 2.3 дах заалтын дагуу шинэчилсэн судалгааны үед судалгаанд хамрагдаагүй үлдсэн өрх, өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд дахин хамрагдах хүсэлтэй нийт 5 өрхийн гаргасан өргөдлийг судалж, дахин үнэлгээний хийхээр төлөвлөөд байна.

“Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн хэмжээнд амьжиргааны түвшин доогуур 81 өрхийг сонгон сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. Үүнд: Сүмбэр сум 55 өрх, Шивээговь суманд 16 өрх, Баянтал суманд 10 өрх шинээр сонгогдсон. Энэхүү ажлын хүрээнд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг зохион байгуулж, өрх иргэдийн судалгааны нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн талаар:

Баянтал, Сүмбэр сумын хөдөөгийн 4 багийн 30 өрхийн 53 малчдад “Малын генетик нөөцийн тухай” хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, хуулиар малчдын хүлээх үүрэг, хариуцлага, малчдад олгосон эрх, Бог малын хээлтүүлэгчийг нийлүүлгийн бус улиралд эх сүргээс нь тусгайлан маллах, мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны талаар, тэдгээртэй хэрхэн хамтран ажиллах зөвлөгөө, малчдад олгодог арьс, шир ноосны урамшуулал, давсны хэрэглээ, хуванцар савны хэрэглээнээс татгалзая зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгч, 7 төрлийн 143 ш гарын авлага, тараах материалыг тараалаа.

Аймгийн хэмжээнд нийт 5110 хээлтэгч төллөж, 5124 төл гарснаас 5110 төл бойжиж, 14 төл хорогдсон байна. Төл бойжилт 99.7 хувь, үүнээс ботго 12, унага 18, тугал 69, хурга 3234, ишиг 1777 байна. Мөн том малын хорогдол 58 байгаагаас үхэр 1, хонь 29, ямаа 28 байна.

Төл бойжилт 2019 оны 03 сарын 13-ны байдлаар:

№		Бүгд	Малын төрөл				
			Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
1	Оны эхний хээлтэгч	203379	407	7569	5929	100638	89037
2	Төллөсөн хээлтэгч	1277	2	0	28	808	439
3	Гарсан төл	1281	2	0	28	812	439
4	Хорогдсон төл: Үүнээс:	Нийт	3	0	0	1	2
		Арьсанд бэлтгэсэн	0	0	0	0	0
6	Бойжиж буй төл	1278	2	0	28	811	437
7	Бойжилтын хувь	99.8	99.8	0	0	99.9	99.5
8	Төллөлтийн хувь	0.6	0	0	0.5	0.8	0.5

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2019 оны 03-р сарын үнийн мэдээ

2 дугаар сарын сүүлч 3 дугаар сарын эхээр малчдаас зах зээлд нийлүүлэгдэж буй махны нийлүүлэлт багассан тул зах зээлд худалдаалагдаж буй зарим төрлийн махны үнэ 50-100 төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөн төмс, хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-100 төгрөгөөр, ургамлын тос 50 төгрөгөөр, алтан тариа 1 дүгээр зэргийн гурил 50 төгрөгөөр, сүү 100 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ/төг/	Доод үнэ/төг/	Өссөн бүүрсан үзүүлэлт/+-/	
1	Үхрийн мах	Ястай	8500	6500	-
		Цул	9500	9500	-
2	Хонины мах	Ястай	6500	5000	+50

		Цул	7000	7000	-
3	Адууны мах	Ястай	7000	5500	-
		Цул	7500	7000	100
4	Ямааны мах	Ястай	5500	4000	-
		Цул	6800	6500	-
5	Тахианы мах	Гуя	8500	8000	-
		Мөч	9200	8500	-
6	Лууван	Монгол	1300	1200	+100
		Хятад	-	-	-
7	Төмс	Монгол	1000	800	-
		Хятад			
8	Байцаа	Монгол	1250	1200	+50
		Хятад	-	-	-
9	Чинжүү	Монгол	-	-	-
		Хятад	6500	5000	-
10	Манжин	Монгол	1300	1200	+50
		Хятад			
11	Сонгино /бөөрөнхий/	Монгол	1800	1600	+200
		Хятад	1200	1000	-
12	Помидор	Монгол	6000	4500	-
13	Өргөст хэмх	Монгол	6500	5500	-
14	Элсэн чихэр	-	2300	2000	-
15	Будаа	Цагаан будаа задгай 1кг /хятад/	2500	2200	-
		Шар слава 1кг	3000	2900	-
		Гурвалжин слава 1 кг	3800	2000	-
16	Сүү	Задгай	2400	2000	+100
		Сүү ХК 0.5л 3.2% тослогтой	-	-	-
		Сүү ХК 1л 3.2% тослогтой	2750	2600	-
17	Тараг	Задгай	-	-	-
		Сүү ХК 1л 3.2% цөцгийтэй	-	-	-
18	Талх	Чойр /Шивээ/	1200	800	
19	Өндөг	ОХУ	450	310	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны талаар:

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 11 ААНБ-ын менежментийн төлөвлөгөөг баталлаа. 2 ААНБ-ын менежментийн төлөвлөгөөг засаж сайжруулахаар зөвлөмж өгсөн. Мөн 2018 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө тайлагнаагүй ААНБ-уудын үйл ажиллагааг шалган зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг 1 ААНБ-д гаргасан.

Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уулын хамгаалалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Сүмбэр сумын БХНСАХ зардлаас Улсын тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх тасалбарыг хэвлүүлэн ашиглаж эхлээд байна.

“Боржигин-2019” наадмыг угтан ард иргэдийн хүрээлэн буй орчинд хандах хандлагыг өөрчлөх замаар хог хаягдлыг бүх нийтийн оролцоотойгоор цэвэрлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, орчин тойрныхоо өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны А/124 дүгээр захирамжаар “Цэвэрхэн наадацгаая” аяныг зарлаад байна.

Энэ жил нийт нутгаар өвөл цас багатай хур тунадас ороогүй байгаа нь хаврын хуурайшилтын улирал эхэлж хээрийн түймэр гарах эрсдэлийг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан болзошгүй хээрийн түймэр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийг мэдлэг, мэдээллээр хангах зорилгоор нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/125 дугаар захирамжаар эргүүл шалгалтын хуваарийг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг угтан Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газартай хамтран ерөнхий боловсролын 1, 2, 5 дугаар сургуулиудад “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” тогтоолыг таниулах, сурталчлах сургалтыг зохион байгуулж, 60 гаруй хүүхдийг хамрууллаа.

Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь 3 дугаар сард найман хугацааны мэдээг 248 удаа, климат агро дундаж мэдээ болон хөдөө, аж ахуйн тойм, 10 хоногийн тойм мэдээг нийт 3 удаа, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

7 хоногийн төлөв, 7 хоногийн тойм мэдээг даваа гариг бүр, сарын урьдчилсан мэдээг 25-ны дотор, сарын тойм мэдээг 5-ны өдрийн дотор тус тус www.govisumber.tsag-agaar.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

3 дугаар сарын 20-ны байдлаар цаг уурын тойм мэдээ 19, 20-ны өдрүүдэд ялимгүй цас орсон. Нийт 0.3 мм тунадастай, салхи 6-20-ны өдрүүдэд 10-15 м/сек хүрч ширүүссэн, бусад хугацаанд 4-9 м/сек салхитай, агаарын дундаж температур 2.8 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь 05-ны шөнө -14,2 градус хүйтэн, хамгийн дулаан нь 18-ны өдөр 14.1 градус дулаан байсан.

Агаар орчны шинжилгээний лаборатори нь азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 3 удаа нийт 33 сорьцын дээж авсан ба 3-р сарын 1-ээс 3 дугаар сарын 25-ны хооронд хийгдсэн 21 удаагийн дээжийн шинжилгээгээр азотын давхар исэл (NO₂) 0.011 мкг/м³ хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.018 мкг/м³ байгаа нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй хэвийн байна.

Тээвэр, авто замын талаар:

Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 3 дугаар сард өссөн дүнгээр 461 тээврийн хэрэгсэл хамрагдлаа.

Хот хооронд 1663 иргэн үйлчлүүлсэн бөгөөд хот доторх 23 таксинд замын худас, 200 ачааны дагалдах хуудас олгож, 81 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэсэн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

2019 оны газрын төлбөрийн орлого 19.132.757 мянган төгрөг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

Сумдын газрын даамлуудын ажиллах ур чадварыг дээшлүүлэх, харилцан мэдээ, мэдээлэл солилцох, туршлага судлуулах, мэргэжил арга зүйгээр хангах зорилгоор Улсын бүртгэлийн багц хуулиар сургалт зохион байгууллаа.

3 дугаар сард “Барилгын материалын үйлдвэрлэгчийг орон нутагт нэмэгдүүлье” сэдэвт аян зарлаж, аяны хүрээнд Орон нутагт барилгын материал болон хөрөнгө оруулалтын ажилд ашиглагдаж байгаа элс, хайрганы ширхэглэг, орц нормыг лабораторийн шинжилгээнд хамруулж, орон нутагт барилгын чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдэд барилгын материалын лабораторын тоног төхөөрөмжийн судалгаа, танилцуулга гарын авлага тараан, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл судалгааг авах ажлуудыг зохион байгууллаа.

Мөн аймгийн “Барилгын салбарын удирдах ажилтны зөвөлгөөн”-ийг 2019 оны 3 дугаар сарын 13- ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр Барилгын хөгжлийн төвийн барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, аймгийн барилгын салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 аж ахуйн нэгж байгууллагын нийт 35 төлөөлөл оролцсон бөгөөд оролцогчдод 2019 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын танилцуулга, цаашид анхаарах асуудлын талаарх мэдээллийг хийж, орон нутгийн барилгын салбарт тулгамдаж буй асуудал сэдвээр харилцан ярилцаж, санал бодлоо солилцлоо. Мөн энэ үеэр Монгол улсын шилдэг инженер хүндэт тэмдэгээр 3 инженерийг шагнаж, урамшууллаа.

Страто ХХК-ний Нүүрс угаах үйлдвэр, НЭБУ ХХК-ний шатахуун түгээх станцын барилга байгууламжид улсын комисс ажиллуулж, үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Худалдан авах ажиллагааны талаар:

2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт **18.6 тэрбум** төгрөгийн **62** ажил тусгагдсан ба нээлттэй тендер шалгаруулалтаар /НТШ/-**29**, харьцуулалтын аргаар-**28**, шууд худалдан авалтаар **-1**, зөвлөх үйлчилгээний-**4** тендер шалгаруулалтуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс нийт төсөвт өртгийн **46.2%**-ийг барилга, **20.8%**-ийг гадна инженерийн шугам сүлжээ,**14.9%**-ийг авто зам, **5.35%**-ийг урсгал зардал, **0.49%**-ийг барилга засвар, **0.77%**-ийг байгаль орчны чиглэлээр, **4.67%**-ийг бараа, тоног төхөөрөмж худалдан авах, **0.7%**-ийг авто замын засвар, арчлалт **0.66%**-ийг зөвлөх үйлчилгээ, **5.46%**-ийг бусад төрлийн ажлууд эзэлж байна.

2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 62 төсөл арга, хэмжээний дагуу үнэлгээний хороог байгуулахаас 40 төсөл арга хэмжээ үнэлгээний хороог байгуулан, 15 төсөл арга хэмжээ буюу 24.1%-ийг цахим системээр зарласан, үлдсэн 25 төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар боловсруулагдаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: “Аймгийн төвийн дугуйн зам /Говьсүмбэр, Сүмбэр сум/”, “Сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум, 1 дүгээр сургууль/” ажлуудын тендер шалгаруулалтыг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр, Орон сууцны тоглоомын талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар байр/”, Үдэлт угталтын хаалга /Говьсүмбэр, Сүмбэр сум/”, Боржигин чуулгын гаднах талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум/” ажлуудын тендер шалгаруулалтыг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр, “Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/”-ын тендерийг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр тус тус зарласан.

Улсын төсвийн урсгал зардлаар: “Зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах /Сүмбэр, “Политехник коллежийн оюутан суралцагчдын хоолонд шаардагдах мах, махан бүтээгдэхүүн” нийлүүлэх, “Политехник коллежийн оюутан суралцагчдын хоолонд шаардагдах хуурай хүнс”, “Политехник коллежийн оюутан суралцагчдын хоолонд шаардагдах хүнсний ногоо” нийлүүлэх ажлуудын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, дүгнэлт зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн.

АОНХСангийн хөрөнгө оруулалт: “Орон нутгийн хөрөнгө оруулалт”-аар хийгдэх “Цагдаагийн хэлтэст эргүүлийн автомашин худалдан авах” ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байгаа, “Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т хог тээвэрлэх автомашин худалдан авах” ажлуудын тендер шалгаруулалтыг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зарласан.

II. ОРОН НУТГИЙН ӨМЧ

Үндэсний статистикийн ерөнхий хороонд нэгтгэгддэг өмчийн хөдлөл, өөрчлөлтийн мэдээ тайланг, батлагдсан ТӨ-1, ТӨ-2, 3,4,5,6,7,8,9,10,11,12,13.1, 13.2 маягтуудын дагуу гарган, орон нутгийн өмчит 43 хуулийн этгээдийн хөрөнгийн мэдээг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хүргүүлсэн. Энэхүү тайлангаар орон нутгийн өмчийн 2018 оны эхний үлдэгдэл 64,4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байсан. 2018 онд шинээр 3,9 тэрбум төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэгдэж, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр 5,8 тэрбум төгрөгийн газар нэмэгдэж, барилга байгууламжийн дахин үнэлгээний хорогдол 14,3 тэрбум төгрөг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр 0,4 тэрбум төгрөгийн хөрөнгө хасагдаж жилийн эцэст 59,5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдсэн урьдчилсан мэдээ гарсан.

Орон нутгийн өмчтэй 43 хуулийн этгээдүүдээс материал бүрэн ирүүлсэн 34 байгууллагатай “Өмч эзэмшүүлэх гэрээ”-г байгуулаад байна. “Өмч эзэмшүүлэх гэрээ” байгуулаагүй, өмчийн мэдээ тайлан хоцроосон байгууллагуудад 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дотор гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/517 тоот албан бичгийн дагуу аймагт 1991-1996 онд хувьчлагдсан 28 хөрөнгийн судалгааг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр гарган хүргүүлсэн.

2019 оны түрээсийн орлогын эхний улирлын төлөвлөгөөний биелэлтийг гаргахад 12,7 сая төгрөг төвлөрөхөөс 9,5 сая төгрөг буюу 75 хувийн биелэлттэй байна. Түрээсийн төлбөр төлөөгүй холбогдох ААНБайгууллага, иргэдээр төлбөр төлүүлэхээр ажиллаж байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум:

Сумын Засаг дарга болон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Цагдаагийн хэлтсээс 2018 онд хийж гүйцэтгэсэн ажил, 2019 онд зохион байгуулах ажлуудаа сумын иргэддээ танилцуулсан.

Гамшгийн эрсдлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь - 2 /LTS2/ төслийн хүрээнд хүн бүр амьдралдаа хэвшил болгож ашиглах боломжтой гурван сумын бүсчлэлийн кодыг хэвлүүлж, иргэд өөрийн багийн бүсчлэлийн кодыг 130105 дугаарт илгээн цаг агаар болон бэлчээрийн мэдээллийг хүлээн авах боломжтой боллоо.

Сумын соёлын төвөөс Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж “Жаргалтай дурсамж-1980” зохиомжит концертийг зохион байгуулсан. Энэ үеэр азтан тодруулж Итгэлт хамба, Улан-Үдэ аялах эрхийн бичиг болон бусад олон олон шагналуудын азтанг тодруулсан.

Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 98 жилийн ой, Халх голын 80 жилийн ойг тохиолдуулан Засаг даргын тамгын газар, Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагч А.Амгалантай хамтран гар бөмбөг, цэрэгжилтийн спорт зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж, сумын Соёлын төвөөс “БИД МАРТАХГҮЙ” ардын авъяастнуудын хамтарсан тоглолтыг иргэддээ өргөн барьсан.

Сумын хэмжээнд 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дуут дохионы бэлэн байдалд 54 албан хаагч, 132 сурагч тус тус хамрагдав.

Баянтал сумын Эрүүл мэндийн төвөөс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэж байгаа бөгөөд 03 дугаар сард нийт 215 үзлэг хийсэн. Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг 89, амбулаторийн үзлэг 155, идэвхитэй хяналт, гэрийн эргэлт 5, алсын дуудлага 8, ойрын дуудлага 13, яаралтай тусламжаар үйлчлүүлсэн 12, хэвтэн эмчлүүлсэн 11, өдрийн эмчилгээгээр 2 иргэн тус тус үйлчлүүлсэн байна. Мөн байгууллагын ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дотоод сургалтыг 2 удаа зохион байгуулсан.

2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 2019 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжих хөтөлбөрийг иргэдэд танилцуулсан.

Сүмбэр сум:

Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газраас "Малчдын зөвлөгөөн"-ийг сумын 6 багийн төлөөлөл 180 малчныг хамруулан зохион байгууллаа. Зөвлөгөөний үеэр тус сумын ЗДТГ 2018 оны үйл ажиллагааны тайлан, 2019 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулсан бөгөөд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Инвест оп монгол ТББ, Монгол даатгал зэрэг байгууллагууд шинээр гарсан хууль тогтоомж, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг, арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн.

Дэлхийн Зөн Олон Улсын байгууллага Бор Өндөр 1 Орон нутгийн хөтөлбөртэй хамтран "Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг" зохион байгууллаа. Сургалтанд хамтарсан багийн 16 гишүүн хамрагдсан бөгөөд "Нөхцөл байдлын үнэлгээ хийх, Өсвөр насны хүүхэдтэй харилцах сэтгэл зүйн үйлчилгээ, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хоорондын уялдаа" сэдвүүдээр сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үр дүнд: Нөхцөл байдлын үнэлгээг журмын дагуу хийснээр хамтарсан багийн бүх гишүүд гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлэх, дүгнэх чадвартай болсон.

Итгэл ивээл төслийн хүрээнд архины хамааралтай иргэдийн дунд 6 сарын вакумжуулсан сургалтанд архины хамааралтай 8 иргэнийг хамруулаад байна.

Хамтарсан багт ирсэн гэр бүлийн хүчирхийллийн 1 тохиолдолд нөхцөл, байдлын үнэлгээ, 2 хүүхдэд эрсдлийн үнэлгээ хийн, холбогдох байгууллагуудад холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн.

Нохой устгалын ажлыг эхлүүлэн сумын төвийн 1,2,3 дугаар багийн нутаг дэвсгэрээр устгалын ажлыг зохион байгуулж нийт 268 нохой устган хогийн цэгт төвлөрүүлсэн.

Сүмбэр сумын ЗДТГ-аас 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зэрлэг ан амьтныг хамгаалах, идэш тэжээлийн дутагдлаас сэргийлэх зорилгоор Их Сансар, бага Сансар, Улаан өндөр гэх маршрутын дагуу 4 цэгт 250 кг хужир, 10 боодол өвс тавьсан.

2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГазар, Политехникийн коллежийн оюутнуудтай хамтран тус сумын 3 дугаар баг Бурхантаас засмал замын төгсгөл хүртэл 2 км замын цэвэрлэгээ үйлчилгээг хийж нийт 2 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэн ажилласан.

Мал үржүүлгийн дэвшилтэт арга болох зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх, иргэд, аж ахуйн нэгжийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төлөвлөж, үржлийн ажил үйлчилгээг оновчтой зохион байгуулах ажлын хүрээнд зохиомлоор хээлтүүлэх бод, бог малын тоог Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс ОНХСангийн үйл ажиллагааны талаар сумын 6 багийн засаг дарга болон багийн ИНХурлын дарга холбогдох албан хаагчдад Сангийн сайдын 288 дугаар тушаалаар батлагдсан журмыг танилцуулж сургалт хийлээ.

Сүмбэр сумын 2019 оны Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлууд:

- Нийтийн эзэмшлийн орон сууцны 2 дугаар байрны подвалын шугам сүлжээний их засварын ажил
- Өрхийн эмнэлэгт авто машины худалдан авах ажил
- 6 дугаар цэцэрлэгийн гадна хашаажуулах ажлын үнэлгээний хороог тус тус байгуулан тендер зарлан ажиллаж байна.

2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн Тамгын газар болон Сүмбэр сумаас “Шүүхийн иргэдийн төлөөлөгч”-өөр сонгогдсон иргэдэд “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-иар сургалт зохион байгуулж төлөөлөгчөөр сонгогдсон 18 иргэн хамрагдаж Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон.

Шивээговь сум:

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, цагдаагийн хэсэг, сумын аж ахуйн нэгж байгууллагуудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулсан.

Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одон шинээр авах иргэдийн материалыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж Алдарт эхийн 1 дүгээр зэргийн одонг 1 иргэн, 2 дугаар зэргийн одонг 11 иргэнд олгохоор боллоо.

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн нээлтийг хийж ХХААГ, Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, сумын ЗДТГ болон сумын 6 байгууллагын 18 албан хаагч 2018 оны ажлын тайлан, 2019 онд хийгдэх ажлаа танилцуулж, шинээр гарсан болон шинэчлэн батлагдсан хуулиудаар мэдээлэл хийлээ. Уг арга хэмжээний үеэр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулан сумын иргэд болон сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийг мах, сүү цагаан идээгээр хангадаг 13 малчин эмэгтэйчүүдийг шагнаж урамшууллаа.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 339, 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх” зарлан мэдээллийн дуут дохиог 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 16:00 цагт сумын хэмжээнд зохион байгуулж сирень дохиог 3 удаа дуугаргаж дадлага сургуулилт хийлээ. Зарлан мэдээллийн дуут дохиогоор Төрийн захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагын ажилчид, ЕБС-ийн

сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, иргэдийг аюулгүйн 4 бүсэд шилжүүлэн байршуулж, үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан. Үүнд 16 төрийн болон төрийн бус байгууллагын 334 албан хаагч, 510 хүүхэд, 25 иргэн нийт 869 иргэн хамрагдсан.

“Хаялга” спорт клубын нэрэмжит Боксын тэмцээнийг зохион байгуулж, 7 аймгийн 19 багийн 170 гаруй тамирчид 16 жинд өрсөлдсөн.

Жудо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд “Хаялга” спорт клубын жудо бөхийн 17 тамирчин хүүхэд оролцож 6 алт, 2 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан.

2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 9389,7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэл 12043,2 мянган төгрөг буюу 120 хувиар давж биелсэн.

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 1 дүгээр улирлын мэдээг гаргаж аймгийн төрийн захиргааны удирдлагын хэлтэст гаргаж хүргүүлсэн. Үүнд: 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар сумын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 34 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 87, нийт 121 өргөдөл хүлээн авсанаас 115 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 1 өргөдлийг дээд шатны байгууллагад шилжүүлж 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатанд байна.

Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй "Нэг хором" аяны хүрээнд аймгийн Цагдаагийн хэлтэс, сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран иргэдэд Зөрчлийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулиудаар сургалт зохион байгуулж 168 иргэн хамрагдсан.

Салхинцэцэг өвчний гаралт ихсэж байгаатай холбогдуулан цэцэрлэгийн хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1044 хүүхдийг хамруулж ангийн багш болон эцэг, эхэд нь зөвлөгөө өгч ажилласан.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярын өдрийг тохиолдуулан Соёлын төвөөс "Орчлонгийн сайхан бүсгүйчүүд танаа", Монгол улсад зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 98 жилийн ойг тохиолдуулан “Орчлонгийн сайхан эрчүүд танаа” хүндэтгэлийн тоглолтуудыг зохион байгуулсан.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эмчтэй хамтран сумын хөгжлийн бэрхшээлтэй 24 иргэнд эрүүл мэндийн сургалт зохион байгуулж сургалтанд хамрагдсан иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж зөвлөгөө өгч ажилласан.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдсан 16 өрхөд “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” сургалтыг 3 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Сургалтанд нийт 16 өрхийн 32 гишүүн хамрагдаж өрхийн хөгжлийн төлөвлөгөөгөө боловсруулсан байна.

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрүүдийг 2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг хэлэлцэн боловсруулж, батлууллаа.

Үүнд: Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 12 ажлыг 6.5 сая төгрөгөөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 11 ажлыг 4.5 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус хэрэгжүүлэхээр баталсан.

Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу ахмад настнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сумын Ахмадын хороотой хамтран “Ахмад мисс-2019” урлагийн арга хэмжээ, “Авьяаслаг ахмад” арга хэмжээг тус тус зохион байгуулж, нийт 80 гаруй ахмад настныг хамрууллаа.

Сумын хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж 24 ААНБ-ын 56 иргэн 4 га талбайн 12м³ хог хаягдлыг түүж цэвэрлэсэн.

2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажил болон 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг гарын авлага болгон бэлтгэж 611 өрхөд тараан танилцуулсан.